

ᠳᠠᠷᠬᠠᠨ - ᠤᠯᠤᠰ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ 2021-2024 ᠣᠨᠤ  
ᠤᠶᠢᠯ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠠᠨᠢ ᠬᠥᠲᠥᠯᠪᠦ᠋᠋᠋᠋ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠶᠦᠯᠡᠬᠤ ᠠᠷᠭᠠ  
ᠬᠡᠮᠵᠡᠭᠡᠨᠢ ᠲᠥᠯᠦᠪᠯᠦᠭᠦ᠋᠋᠋᠋ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠦᠳᠦ ᠬᠢᠶᠰᠢᠨ  
ᠬᠢᠶᠠᠯᠲ-ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡ, ᠤᠨᠡᠯᠭᠡᠨᠢ ᠲᠠᠨᠢᠯᠴᠢᠭᠤᠯᠠ

# “ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

*Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс*

*2024.09.18*



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ТӨЛӨВЛӨГӨӨ НЬ НИЙТ 6 БҮЛЭГ, 21  
ДЭД БҮЛЭГ, 66 ЗОРИЛТ 318 АРГА  
ХЭМЖЭЭ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 57

Дархан

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны  
хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.1.8, 48 дугаар зүйлийн 48.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8, 19 дүгээр зүйлийн 19.2, 19.4 дэх заалт, Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлж буй "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 02/08 дугаар тогтоолын хавсралтад "долоодугаар" бүлгийг нэмсүгэй.

2. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд агуулгын хувьд давхцаж буй /1.4.1; 2.2.1.3; 2.3.1.2; 2.6.2.1; 2.6.2.3; 2.7.2.10; 3.2.1; 4.1.2.3; 4.2.2; 5.1.3.2;/ заалтууд, хөрөнгийн асуудал нь шийдэгдээгүй, хэрэгжих боломжгүй /1.5.4.4; 2.2.1.4/ заалтуудыг тус тус хассугай.

3. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Б.Азжаргал)-д даалгасугай.

ДАРГА

С.НАСАНБАТ

**7 бүлэг, 80 зорилтын 323 арга**  
**ХЭМЖЭЭ**-ний хэрэгжилтийн үнэлгээ  
**95.69** хувь буюу **4.78** оноо

“Дархан-Уул Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг **БОДЛОГО** тус бүрээр харуулбал:

№	Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	Хүний хөгжлийн бодлого	24	115	96.48% буюу 4.82 оноо
2	Эдийн засгийн бодлого	17	100	94.64% буюу 4.73 оноо
3	Засаглалын бодлого	9	38	96.88% буюу 4.84 оноо
4	Ногоон хөгжлийн бодлого	7	22	94.71% буюу 4.73 оноо
5	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	3	11	84.54% буюу 4.22 оноо
6	Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	3	10	99.0% буюу 4.95 оноо
7	Шинэ сэргэлтийн бодлого	17	27	95.92% буюу 4.79 оноо
<b>Ерөнхий, дундаж үнэлгээ</b>		<b>80</b>	<b>323</b>	<b>95.69% буюу 4.78 оноо</b>

Хүний хөгжлийн бодлого

Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг **ҮНЭЛГЭЭНИЙ ШАТЛАЛААР** задалж харуулбал:

№	Хэрэгжилтийн үнэлгээ, хувь	Арга хэмжээний тоо, эзлэх хувь
1	Үр дүнтэй буюу 100.0 %	256 (79.25%)
2	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90.0%	46 (14.24%)
3	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	13 (4.02%)
4	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	4 (1.23%)
5	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	2 (0.61%)
6	Үр дүнгүй 0.0%	2 (0.61%)



“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д хэрэгжүүлэхээр тусгасан 323 арга хэмжээнээс 315 арга хэмжээг **ХАНГАЛТТАЙ** гэж үнэлэв.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Хэрэгжилт	Бүгд	БОДЛОГО ТУС БҮРЭЭР																											
		1.Хүний хөгжил						2.Эдийн засгийн бодлого							3.Засаглалын бодлого			4.Ногоон хөгжлийн бодлого		5.Бүс орон нутгийн хөгжлийн бодлого	6.Халдварт цар тахлаас үүдэлтэй ЭЗНХД ТБ	7. Шинэ сэргэлтийн бодлого							
		Эрүүл мэнд	Биеийн тамир	Боловсрол	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Соёл, урлаг	Дүн	Санхүү, төсвийн зохицуулалт	Уул уурхай, хүнд үйлдвэр	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэр	Аялал жуулчлал	Эрчим хүч	Зам тээвэр, ложистик	Барилга хот байгууламж	Дүн	Төрийн удирдлагын бодлого	Гамшгаас урьдчилан сэргэйлгэх БХБ	Хууль эрхзүйн бодлого	Дүн	Ногоон хөгжил	Нүүрс төрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй НХ	Дүн	Бүс орон нутгийн хөгжил	Дүн	Халдварт цар тахлаас үүдэлтэй ЭЗНХДТБ	Дүн	7.1.1-7.17.1	Дүн	
Зорилтын тоо	<b>80</b>	5	3	4	11	1	<b>24</b>	4	1	3	2	1	2	4	<b>17</b>	4	2	3	<b>9</b>	4	3	<b>7</b>	3	<b>3</b>	3	<b>3</b>	17	<b>16</b>	
Арга хэмжээний тоо	<b>323</b>	32	14	20	42	7	<b>115</b>	12	3	25	9	7	11	33	<b>100</b>	19	7	12	<b>38</b>	15	7	<b>22</b>	11	<b>11</b>	10	<b>10</b>	27	<b>27</b>	
Үүнээс:	100 хувь	<b>256</b>	24	13	18	28	7	<b>90</b>	11	1	21	8	6	8	24	<b>79</b>	18	6	10	<b>34</b>	12	3	<b>15</b>	5	<b>5</b>	9	<b>9</b>	24	<b>24</b>
	90 хувь	<b>46</b>	5		2	13		<b>20</b>	1	1	4		1	1	3	<b>11</b>	1		2	<b>3</b>	3	3	<b>6</b>	4	<b>4</b>	1	<b>1</b>	1	<b>1</b>
	70 хувь	<b>13</b>	2			1		<b>3</b>		1		1		1	5	<b>8</b>				<b>0</b>		1	<b>1</b>	1	<b>1</b>		<b>0</b>		<b>0</b>
	50 хувь	<b>4</b>						<b>0</b>						1	1	<b>1</b>		1		<b>1</b>			<b>0</b>		<b>0</b>		<b>0</b>	2	<b>2</b>
	30 хувь	<b>2</b>	1					<b>1</b>								<b>1</b>				<b>0</b>			<b>0</b>		<b>0</b>		<b>0</b>		<b>0</b>
	0 хувь	<b>2</b>		1				<b>1</b>								<b>0</b>				<b>0</b>			<b>0</b>	1	<b>1</b>		<b>0</b>		<b>0</b>
Хэрэгжилтийн хувь	<b>95.69%</b>	94	93	99	96	100	<b>96.5</b>	99.16	86.66	98.4	96.66	98.57	90	93.03	<b>94.64</b>	99.47	92.85	98.33	<b>96.88</b>	98	91.42	<b>94.71</b>	84.54	<b>84.54</b>	99	<b>99</b>	95.92	<b>95.92</b>	
Хэрэгжилтийн оноо	<b>4.78</b>	4.7	4.6	5	4.8	5	<b>4.82</b>	4.95	4.33	4.92	4.83	4.92	4.5	4.65	<b>4.73</b>	4.97	4.64	4.91	<b>4.84</b>	4.9	4.57	<b>4.735</b>	4.22	<b>4.22</b>	4.95	<b>4.95</b>	4.79	<b>4.79</b>	

## Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ

Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт болон тухайн жилд дэвшүүлсэн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу **50.0%, 30.0%, 0%-иар** үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

№	Үнэлгээ	Тоо	Арга хэмжээний дугаар
1	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	4	183, 238, 298,299
2	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	2	10,178
3	Үр дүнгүй 0.0%	2	44,282

Handwritten notes in Mongolian script on the left margin.

**Үр дүнгүй буюу 0.0%-иар үнэлэгдсэн 2 арга хэмжээг дэлгэрэнгүй үзүүлбэл:**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
44	1.2.3.3. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажлыг хийнэ.	Дархан сумын 3 дугаар багт байрлах Төв цэнгэлдэх хүрээлэнг 4 улирлын турш байнгын үйл ажиллагаатай болгон шинэчлэхээр “Мөрөөдлийн талбай” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд төв цэнгэлдэх хүрээлэнг засварлах төндэрийг зарлах бэлтгэл ажил хийгдэж байна.	0
282	5.1.3.1. Дархан үйлдвэр технологийн парк”-ийн ТЭЗҮ боловсруулж, ҮТП-ын 1, 2 дугаар бүсэд үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 2/02 дугаарт тогтоолоор “Дархан үйлдвэр технологийн парк” ОНӨААТҮГ-ын ТЭЗҮ боловсруулах ажилд 50.0 сая төгрөгийг батлан шийдвэрлэж өгсөн боловч уг газар нь нэгдүгээрт тухайн ажлыг хугацаанд нь хийгээгүй, хоёрдугаарт ТЭЗҮ боловсруулах ажлыг зах зээлийн ханш нь 250 сая төгрөгөөр хийхээр санал ирсэн зэрэг шалтгааныг үндэслэн байнгын хороо нь төсвийн тодотгол хийх замаар аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 01 дугаарт тогтоолоор хөрөнгийн эх үүсвэрийг өөр зүйлд зарцуулахаар шийдвэрлэсэн байна.	0



## Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%-иар үнэлэгдсэн 2 арга хэмжээг дэлгэрэнгүй үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх арга ХЭМЖЭЭ	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
10	1.1.2.1. Зоонозын төвийн харьяа нэгж байгуулна.	Зоонозын Өвчин Судлалын Төв /цаашид ЗӨСТ гэх/-ийн барилга нь аймгийн төвүүдэд байгуулах барилгын нэг маягийн зураг төслөөр баригдахаар болсон бөгөөд 2023 оны УТХО-нд Дархан-Уул аймагт баригдах ЗӨСТ-ийн барилгын холболтын зураг, төсвийн 25.8 сая төгрөг батлагдсан. Иймд ЗӨСТ-ийн барилга барих газрыг Дархан сумын 13-р баг, Үйлдвэрчний 2-р гудамж 203А байршилд аймгийн Засаг даргын 2023 оны А/280 дугаар захирамжаар 3000м <sup>2</sup> газрыг ЭМГ-ын нэр дээр олгосон. Олгогдсон газарт барилгын холболтын зураг хийхэд шаардлагатай зургийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулж ЭМЯ-д хүргүүлэн, тус яамнаас тендер зарлуулахаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Мөн техникийн нөхцөлүүдийг гаргаж 2023 оны 11 сард ЭМЯ-нд хүргүүлсэн. 2024 онд ЭМЯ-аас хариу ирүүлээгүй, төсөвт тусаагүй.	30%
178	2.6.1.5. Энхтал багийг аймгийн төвтэй холбох 13.4км сайжруулсан шороон зам шинээр барина.	Энхтал багийг аймгийн төвтэй холбох 13.4 км сайжруулсан шороон зам шинээр барих ажлын зураг, төсөв боловсруулсан. 2025 онд УТХО-ийн төсвийн төсөлд саналыг хүргүүлсэн.  Үр дүн: 13.4 км сайжруулсан шороон замын зураг төсөв боловсруулсан.	30%

## Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%-иар үнэлэгдсэн 4 арга хэмжээг дэлгэрэнгүй үзүүлбэл:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
183	2.7.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгож, хэрэгжилтийг хангуулна.	<p>Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгож ажлыг Газар дэлхий ХХК нь тендерт шалгаран 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр К1015166 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Уг ажлыг 420,000,000.0 /Дөрвөн зуун хорин сая/- төгрөгөөр хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн./орон нутгийн төсөв, Хонгор сумын ОНХС/.</p> <p>Газар дэлхий ХХК нь бэлтгэл үе шат болон хээрийн судалгааны 1 дүгээр үе шатны ажлуудаа гүйцэтгэн гэрээний дагуу явцын 1, 2 дугаар тайлангаа аймгийн Засаг даргын 2024-08-30 өдрийн 01-А/368 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2024-09-09 өдөр танилцуулсан.</p>	50%
238	3.3.1.4. Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын системийн тоог жилд нэгээр нэмж байгуулна.	<p>Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын систем нь 2019 онд Дархан сумын 9, 15-р багт хийгдсэн байна. 2021-2023 онд дахин аянга зайлуулах хамгаалалтын систем хийх төсвийг шийдвэрлэх боломжгүй байсан.</p> <p>2024 онд аянга зайлуулагч, хамгаалалтын системийг хийж гүйцэтгүүлэн ажиллахыг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр биелэлтийг авахаар ажиллаж байна.</p> <p>Үр дүн: 2024 онд аянга зайлуулагч хийж гүйцэтгэх ажлыг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдууд зохион байгуулан биелэлтийг хангуулна. Төсвийн тодотголд 20 сая төгрөг санал оруулсан.</p>	50%

298	7.2.1. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	<p>“Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь “Дархан” ҮТП-ийн хүрээнд “Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төсөл, Төмөртэйн уурхайн “Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэр”-ийн төсөл болон “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p>“Эрдэнэс Монгол” ХХК-иас 6 үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө тусгаж “Монгол ган цогцолбор I” төслийн нэр, хүчин чадлыг өсгөж “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төсөл болгон хэрэгжүүлэхээр болсон.</p> <p>“Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-г боловсруулж ЭБМЗ-өөр 2024 оны 06 сарын 24 өдөр хэлэлцүүлж хүлээн авах шийдвэр гарсан. Төслийн дараагийн шатны ажлуудыг эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>“Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэр”-ийн төсөл болон “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс ҮТП” ХХК-иар хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулж байна.</p>	50%
299	5.1.3.2. “Дархан арьс ширний цогцолбор” шинээр барьж ашиглалтад оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	<p>Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018.08.17-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Дархан арьс ширний цогцолбор” байгуулах шийдвэр гарч 180 га газрыг олгосон. “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мян.т ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд өмнөх онд хийгдсэн. Дархан арьс ширний цогцолбор ТӨХК-д аймгаас 25 га талбай газрыг олгож, бүтээн байгуулалтыг дэмжиж ажиллаж байна.</p>	50%

ᠲᠠᠪᠦᠬᠡᠨᠳᠦᠠᠮᠵᠢᠯᠲᠦᠬᠦᠰᠦᠢ

# ТА БҮХЭНД АМЖИЛТ ХҮСЬЕ

